


НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН САРЫН МЭДЭЭНИЙ ТОЙМ

2012 оны
04-р сар

Нийгмийн даатгалын санд 2012 оны 4-р сарын 30-ны байдлаар нийт 210.1 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 131.9 хувиар биеллэсэн байна. Даатгалын сангуудаас давхардсан тоогоор 1265.2 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардалд нийт 233.4 тэрбум төгрөг зарцуулжээ. Улсын төсвөөс 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон иэргийн тэтгэвэрт 90.7 тэрбум төгрөгийг тэтгэврийн даатгалын санд шилжүүлжээ.

Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, тэрбум төгрөгөөр



Нийгмийн даатгалын хамралт, шимтгэлийн орлого

2012 оны 4-р сарын мэдээгээр нийгмийн даатгалд 25.7 мянган аж ахуйн нэгж байгууллага, 528.5 мянган заавал даатгуулагч, 61.6 мянган сайн дурын даатгуулагч шимтгэл төлсөн байна. Эрүүл мэндийн даатгалд нийт 1431.4 мянган хүн хамрагджээ.

Нийгмийн даатгалын таван төрлийн санд тухайн сард 52.8 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17.5 тэрбум төгрөгөөр өсчээ.

Нийгмийн даатгалын сангуудаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээний зардалд энэ сард 82.3 тэрбум төгрөг зарцуулжээ. Төлөвлөсөн зардал 92.3 хувиар биелэж, 19.4 тэрбум төгрөг хэмнэгдсэн байна.


Тэтгэврийн даатгалын сан

Тухайн сард тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 297.4 мянган иргэдийн тэтгэвэрт 68.4 тэрбум төгрөг зарцуулжээ. Нийт зардлын 70.7 хувь буюу 48.4 тэрбум төгрөгийг өндөр насны тэтгэвэр авагч 207.4 мянган иргэнд зарцуулсан байна. Засгийн газрын “Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 80 дугаар тогтоолын дагуу тэтгэврийг нэмэгдүүлж 2, 3, 4 дүгээр саруудын тэтгэврийн зөрүү 21.8 тэрбум төгрөгийг олгосонтой холбоотойгоор тэтгэврийн даатгалын сангийн зардал өмнөх онтой харьцуулахад 43 хувиар өссөн байна.

Тэтгэврийн даатгалын сангийн орлого, зарлага, тэрбум төгрөгөөр



Тэтгэмжийн даатгалын сангийн орлого, зарлага, тэрбум төгрөгөөр



Тэтгэмжийн даатгалын сан

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмж авсан 13.8 мянган иргэнд 2.6 тэрбум төгрөг зарцуулсан нь өнгөрсөн сараас 1.3 тэрбум төгрөгөөр буурсан байна. Нийт зардлын 68.6 хувь буюу 1.8 тэрбум төгрөгийг жирэмсний болон амаржсаны тэтгэмжид зарцуулжээ

ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага, сая төгрөгөөр

	2011_4 сар	2012_4 сар	Зөрүү
Тахир дутуугийн Тэжээгчээ алдсаны Тэтгэмж, төлбөрийн Сувиллын	1 306.0	1 904.1	598.1
	119.8	193.3	73.4
	27.0	31.6	4.7
	18.6	52.2	33.6
Нийт дүн	1 471.4	2 181.2	709.8

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан

Тус сангаас 4-р сард 7.2 мянган тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчдын тэтгэвэрт 2.1 тэрбум төгрөг, 106 хүнд хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, рашаан сувилалд ирж, буцах болон сувиллын зардал, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд нийт 83.8 сая төгрөгийг тус тус зарцуулав. Сангийн зардал өмнөх оны мөн үеэс 658 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Ажилгүйдлийн даатгалын сан

2012 оны 4-р сарын мэдээгээр ажилгүйдлийн даатгалын сангаас 750 хүнд 411.6 сая төгрөгийг ажилгүйдлийн даатгалын тэтгэмж, сургалтын зардалд зарцуулсан нь 2011 оны мөн үетэй харьцуулахад 171.9 сая төгрөгөөр буурчээ. Ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо өмнөх оны мөн үеэс 234 хүнээр, нэг хүнд ногдох тэтгэмжийн хэмжээ тус тус буурсантай холбоотой ажилгүйдлийн сангийн зардал буурсан байна.

Ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага, сая төгрөгөөр

	2011_4 сар	2012_4 сар	Зөрүү
Ажилгүйдлийн тэтгэмж	582.5	411.5	170.9
Сургалтын зардал	1.0	0.1	1.0
Нийт дүн	583.5	411.6	171.9

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага, сая төгрөгөөр

	2011_4 сар	2012_4 сар	Зөрүү
Эмнэлгийн эмчилгээний зардал	5 349.5	8 147.6	2 798.1
Рашаан сувиллын зардал	106.6	392.3	285.6
Эмийн үнийн хөнгөлөлт	143.6	243.4	99.8
Нийт дүн	5 599.7	8 783.3	3 183.5


Эрүүл мэндийн даатгалын сан

Тухайн сард эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан 409.7 мянган хүний зардалд 8.8 тэрбум төгрөг зарцуулсан байна. Нийт зардлын 92.7 хувийг эмнэлгийн тусламж үйлчилгээний зардалд, 2.8 хувийг рашаан сувилалд, 4.5 хувийг эмийн үнийн хөнгөлөлтөд тус тус зарцуулав.

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 19.6 тэрбум төгрөг байна. Нийт шимтгэлийн авлагын 90.9 хувь буюу 17.9 тэрбум төгрөгийг аж ахуйн нэгж байгууллагуудын авлага эзэлж байна. Нийт авлагын 39.4 хувь буюу 7.8 тэрбум төгрөгийг 121 дээш хоногтой хуримтлагдсан авлагын дүн эзэлж байна. Нийслэлийн дүүргүүдийн шимтгэлийн авлага 11,5 тэрбум төгрөг болж оны эхнээс 2,2 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага, 2012 оны 4 сар, сая төгрөгөөр



Үйл ажиллагааны зардал, сая төгрөгөөр

	2011_4 сар	2012_4 сар	Өөрчлөлт	
			Тоогоор	Хувиар
Цалингийн сан, нийгмийн даатгалын шимтгэл	2708.2	3143.8	435.6	116.1%
Бараа үйлчилгээний бусад зардал	935.8	1048.5	112.7	112.0%
Дүн	2731.3	3019.8	288.5	110.6%

Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардал

Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардалд нийт 5299.8 сая төгрөг төлөвлөснөөс 4192.3 сая төгрөг зарцуулж, 1107.5 сая төгрөг хэмнэгдсэн байна. Уг зардал нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 115% буюу 548.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.